



МОНГОЛЫН НОГООН НАМ


2004 оны 4 дугаар
сарын 16 ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар
Факс: 976-11-329103

Монголын Ногоон намын Тэргүүлэгчдийн Зөвлөлөөс тогтоох нь:

1. 2004 оны Монгол улсын Их хурлын ээлжит сонгуульд Монголын Ногоон нам оролцох нь зүйтэй гэж үзсүгэй.
2. Сонгуульд оролцоход Ногоон намаас баримтлах чиглэл, хөтөлбөрийг боловсруулж намын бага хурлаар хэлэлцүүлэхийг Намын дарга Д.Басандоржид даалсугай.
3. Ардчилсан намтай байгуулсан урт хугацааны хамтын ажиллагааны хүрээнд "Эх орон Ардчилал" эвсэлтэй хамтран ажиллах нь зүйтэй гэж үзсүгэй.

Хурлын тэргүүлэгчдийн дарга  Д.Басандорж

Нарийн бичгийн дарга

 О.Бумялагч

2004 оны 4 сарын 16

АЛИВАД НАЙР УЛС ТӨРИЙН АМЬДРАЛД ОРОЛ-
ЛОХ ДОО БНМАУ-ЫН БҮРЭН ЭРХ, ТУСГААР ТОГТ-
НОЛ ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЛИЙГ САХИН ХАМ-
ГААЛЖ ҮНДСЭН ХУУЛЬ БОЛОН ТӨРИЙН БУСАД
ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХҮНДЭЛГЭН БИЕДУУДАЖ
МОНГОЛ ЭХ ОРОН АРД ТҮМНИЙ ЭРХ АШИГТ
НИЙЦСЭН ХИЛ АЖИЛАЛАГАА ЯВУУЛАХ ҮҮРЭГТЭЙ.

БНМАУ-ын Дээд шүүхийн

Эрхэмхэн Шүүх Колежийн

Шүүгчийн Дарга


19 90 оны 5-р сарын 26-ны өдрийн 6-р тогтоолоор

Мөнхсүхтэн Шогоон


Намыг улсын бүртгэлд бүртгэж өөрийн дүрэм мөрийн хөтөл-
бөрийнхөө дагуу БНМАУ-ын нутаг дэвсгэрт улс төрийн үйл
ажиллагаа явуулахыг зөвшөөрөв.

ТАЛИГА

ДАРГА



ГИШҮҮН





МОНГОЛЫН НОГООН НАМ

2004 оны 5 дугаар
сарын 24 ны өдөр

Дугаар 18

Улаанбаатар
Факс: 976-11-329103

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНД

Бодлогын чиглэл хүргүүлэх тухай

МНН-ын Бага хурлаас сайшаагдан батлагдсан 2004 оны сонгуульд оролцохдоо баримтлах намын бодлогын чиглэл, үзэл баримтлалыг хүргүүлэв.



НАМЫН ДАРГА

Д.БАСАНДОРЖ

МННамын 2004 оны УИХ-ын сонгуульд оролцох үзэл баримтлал бодлогын чиглэл:

- Монгол улсын тогтвортой хөгжлийг хангах зорилгоор нийгэм –экологийн баримжаатай эдийн засгийн оновчтой бүтцийг бүрдүүлэх;
- Монгол улсын хөгжлийн урт хугацааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх, газар зүй, экологи-эдийн засгийн мужлалаар бүсчилэн хөгжүүлэх ;
- Төрийн байгууллалт, нутаг дэвсгэрийн бүтэц зохион байгуулалт, түүний эрх зүйн орчинг боловсронгуй болгох замаар авилгал, хээл хахуультай тэмцэж, шударга ёсыг бэхжүүлэх;
- Боловсролыг төрийн бодлогын энэ тэргүүний зорилт болгох, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудлыг үндэсний хөгжлийн бодлогоор зохицуулах чиглэлийг баримтлах;
- Байгалийн нөөц баялагыг аль болох иж бүрэн, хаягдалгүй технологиор ашиглах бодлогыг баримталж, доройтсон орчныг нөхөн сэргээх болон нөөц баялагыг зохистой ашиглах хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох;
- Орчны бохирдлыг багасгах, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох, " ашиглагч ба бохирдуулагч нь төлөх" байгаль орчны менежментийн шинэ тогтолцоог бий болгох;
- Экологийн цэвэр үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогын хүрээнд үндэсний болон жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдад эдийн засаг, эрх зүйн таатай, найдвартай орчин бүрдүүлэх;
- Монголын хөдөөг эрчимтэй хөгжүүлэх, байгалийн гамшгийн даатгалын тогтолцоог бүрдүүлэх, говь, хээрийн сумдын түлш, дулаан хангамжийн асуудлыг шийдвэрлэх, усан хангамж, ариун цэврийн нөхцлийг сайжруулахад түлхүү анхаарах;
- Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг нэмэгдүүлэх, менежментийг сайжруулах, ховор, ховордсон амьтан, ургамал болон биологийн төрөл зүйлийг хамгаалах;
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний цар хүрээг нэмэгдүүлж, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээг улсын төсвийн 10%-иас бууруулахгүй байх бодлого барих, байгаль орчны салбарт гадаадын дэмжлэг тусламжийг түлхүү авах нөхцлийг бүрдүүлэх;
- Ган, цөлжилт, байгалийн гамшигтай тэмцэх менежментийг боловсронгуй болгох, усны нөөцийг зүй зохистой ашиглах, усны ай савын стратегийн төлөвлөлтийн зарчмыг нэвтрүүлэх;
- Газар ашиглалт, эзэмшил, өмчлөлийн оновчтой нөхцөл бүрдүүлж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, бэлчээрийн менежментийг сайжруулах